

**“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хууль, тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага.**

**1.1 Хууль зүйн үндэслэл, шаардлага.**

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно” гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.6-д “төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.4-т “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.4.1-т “чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлнэ”. 5.4.3-т “Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

**1.2 Практик хэрэгцээ шаардлага.**

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.2.6-т “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин, хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, 3.3.2.7-т “Төрийн албан хаагчид аюулгүй байдлын мэдлэг олгож, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх, шударгаар өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрдүүлж, сонирхлын зөрчлийг хуулиар хязгаарлана” гэж тусгаж, шинэ үеийн төрийн албаны хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон болно.

Түүнчлэн засаглалыг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албаны ил тод, хариуцлагатай, шударга үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ төрийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүрт тавих зэрэг шаардлага байгааг үндэслэн төрөөс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлан мөрдүүлж байна.

Гэвч бодит байдал дээр Монгол Улсын засаг захиргааны нэгжийн анхан шат болох баг, хорооны Засаг дарга нь хэт улс төржсөн шийдвэр гаргах, томилогдсон улс төрийн албан тушаалтан нь ёс зүй, мэргэжил, ур чадварын хувьд хангалтгүй байх үзэгдэл хэвээр байна.

Монгол Улсын хэмжээнд баг, хорооны статистик тоон дүнг авч үзвэл.<sup>1</sup>

Баг, хороо	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Улсын дүн	1,754	1,765	1,765	1,767	1,770	1,808	1,810	1,810	1,849
Аймгийн дүн	1,602	1,613	1,613	1,615	1,618	1,639	1,639	1,639	1,645

Өнөөгийн Монгол Улсын жишгээс харахад баг, хорооны Засаг даргыг сонгох Иргэдийн нийтийн хуралд “ургийн” сонгууль явагдах магадлал өндөр болсон. Тиймээс баг, хорооны Засаг даргыг томилох нь улс төржилтийг бууруулна. Багийн Засаг даргыг багийн хүн амын тооноос хамаарч Иргэдийн Нийтийн Хурлын сонгуульгүйгээр томилдог болох хэрэгцээ шаардлага бодиттой бий болсон байна.

Мөн төрийн албаны тушаалын ангиллыг өөрчлөн баталсан байдаг. Тухайлбал, Төрийн албаны тухай хуульд 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтныг төрийн тусгай албан тушаалтанд хамруулсан. 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг зохицуулалтаар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийг төрийн улс төрийн албан тушаалтанд хамааруулсан зэрэг өөрчлөлтүүд байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан, төрийн албаны хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн мэдлэг ур чадвартай, мэргэшсэн, ёс зүйтэй төрийн албыг хөгжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалтад “тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулахаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан” бол хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал хамаарахгүй гэж заасан бөгөөд хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд зөвхөн хуулиар зохицуулахаар заасан харилцаа тул уг судалгааг хийх шаардлагагүй болно.

**Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ.**

Хуулийн төслийн зорилго нь төрийн албаны тодорхой албан тушаалыг ангилалтыг өөрчлөх буюу баг, хорооны Засаг даргыг төрийн захиргааны албан тушаалтан болгох талаар хуульд тусгах, төрийн баталсан бодлогын хууль зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангахад оршино.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дүгээр зүйлийн 22.1.2 дахь заалтын дагуу өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд төсөлд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалтыг тусгана. Хуулийн төсөл нь 3 зүйлтэй байх бөгөөд 1 зүйлд төрийн захиргааны албан

<sup>1</sup> Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газрын 2024 оны шинэчилсэн тоон судалгаа [https://www.1212.mn/mn/statistic/statcate/573081/table-view/DT\\_NSQ\\_0100\\_001V1](https://www.1212.mn/mn/statistic/statcate/573081/table-view/DT_NSQ_0100_001V1)

тушаалд баг, хорооны Засаг даргыг нэмэх, 2 дугаар зүйлд хуулийн заалтад өөрчлөлт оруулах, 3 дугаар зүйлд дагаж хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгасан.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуультай зөрчилдөөнгүй нийцүүлэх үүднээс дагалдах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна. Тус дагалдах хуулиудад Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг байна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал.**

### *3.1. Эдийн засгийн үр дагаврын хүрээнд.*

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад төсвийн дарамт учруулахгүй ба нэмэлт ажлын байр шаардлагагүй болно. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан хууль тогтоомжийн хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоо хийх шаардлагагүй.

### *3.2. Нийгмийн үр дагаврын хүрээнд.*

Баг, хорооны Засаг даргыг төрийн захиргааны албан тушаалтан болгон сонгон шалгаруулалтад үндэслэн шууд томилох зохицуулалтыг хуульчилснаар төрийн албаны мэдлэг, ур чадвар дээшлэх, төрийн албаны нэр хүнд сэргэх, ёс зүй, хариуцлага нэмэгдэх, нийгэмд иргэдийн дунд байгаа сөрөг үзэл бодлыг өөрчлөх ач холбогдолтой. Төрийн албаны хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил, мэдлэг, ур чадварын дутагдал, ёс зүй, хариуцлагагүй байдал зэрэг сөрөг үр дагавруудыг өөрчлөх юм.

### *3.3. Хууль зүйн үр дагаврын хүрээнд.*

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх ач холбогдолтой юм.

**Дөрөв. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн төслийн талаар.**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

## **ХУУЛЬ САНААЧЛАГЧ**